# “ШАРЫН ГОЛ” ХК
# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
# ХУРЛЫН МАТЕРИАЛ

2023 оны 04 сарын 21

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН**
**ХУРЛЫН МАТЕРИАЛ**

**ГАРЧИГ**


1. Мэндчилгээ
2. “Шарын гол” ХК-ийн танилцуулга
3. ХЭХ-ын үйл ажиллагааны дараалал
4. Хуралд хэлэлцэх асуудал
5. 2022 оны үйл ажиллагааны тайлан
6. 2022 оны аудитын тайлан /хураангуй/
7. Компанийн засаглал, ТУЗ-ийн ажлын тайлан
8. ТУЗ-ийн хурлын тогтоол
9. ХЭХ-ын тогтоолын төсөл
10. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулга
11. ТУЗ-ийн хурлын тогтоол
12. Санал авах хуудас

# *МЭНДЧИЛГЭЭ*



Монгол улс, бүс орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулан, оюун ухаан хүч хөдөлмөрөө зориулж, үндсэн үүргээ биелүүлсээр ирсэн тус компанийн нийт уурхайчид, хувьцаа эзэмшигчид, хамтран ажиллагч түнш байгууллага хамт олон та бүхэнд сайн сайхан бүхнийг хүсэн мэндчилье.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаандаа компанийн засаглалын кодекс, зарчмыг мөрдлөг болгон компанийн засаглалын хөгжлийг манлайлагчдын эгнээнд хүрч ажиллахыг зорин ажиллаж байгаа билээ.

Тус компани нь Монгол улсын эдийн засгийн хямралыг даван туулж буй энэ цаг үед компанийн гол зорилго болсон дэлхийн стандартад нийцсэн уул уурхайн компани болох хөгжлийн ирээдүйд чиглэсэн бодлого тодорхойлж боловсронгуй болгон түүнийг хэрэгжүүлэхэд төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны үйл ажиллагаа чиглэж ирлээ.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үйлдвэрийн шинэчлэл, цаашдын үйл ажиллагааны өрнөлттэй уялдуулан зайлшгүй шаардлагатай байгаа машин техник үндсэн хөрөнгө худалдаж авах, түрээсээр авч ажиллуулах тухай үйлдвэрийн үйл ажиллагаатай холбогдсон асуудал, компанийн удирдлага нэгжийн шинэчилсэн бүтцийн тухай, удирлага зохион байгуулалтын асуудал зэрэг онцгой чухал асуудлыг тухай бүрд нь хэлэлцэж зохих шийдвэрийг гаргаж удирдамжаар хангаж байлаа.

Бидний цаашдын хөгжил дэвшилд хүрэх зорилго, зорилтоо биелүүлэхэд хувьцаа эзэмшигчид, харилцагч түнш байгууллагууд, уурхайчид нийт хамт олны хүч хөдөлмөр, хичээл зүтгэлээс шалтгаалан, хүндрэл бэрхшээлийг даван туулна гэдэгт итгэл төгс байгаагаа илэрхийлье.

Та бүхэнд ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ТУЗ-ИЙН ДАРГА Г.ХУЛАН

# *МЭНДЧИЛГЭЭ*



“Шарын гол” ХК-ийн Хувьцаа эзэмшигчид та бид компанийн 2022 оны үйл ажиллагааны талаар тайлагнан хэлэлцэхээр ээлжит хурлаа хуралдах гэж байна.

2022 оны нүүрс олборлолтын төлөвлөгөө 108%, нүүрс борлуулалтын төлөвлөгөө 110%-иар биелүүлж, улс орныхоо хойд бүс буюу Дархан, Эрдэнэтийн эрчим хүчний үйлдвэрүүдийн хэрэгцээг хангаж олборлосон нүүрснийхээ 90 гаруй хувийг эрчим хүчний хэрэглээн нийлүүлж бусад үйлдвэрүүд, жижиг хэрэглэгчдийг нүүрсээр хангах үүргээ амжилттай биелүүллээ.

Бид 2022 оны хөрс хуулалтын төлөвлөгөө 88%-тай байсан бөгөөд зорилго зорилтоо биелүүлэхэд хувьцаа эзэмшигчид, хамтран ажиллагч түнш байгууллагын санал зөвлөмж, идэвхитэй үйл ажиллагаа бөгөөд уурхайчин хамт олны сэтгэл, зүтгэл онцгой нөлөөтэй гэдгийг тэмдэглэж зорьсондоо хүрнэ гэдэгт итгэл төгс байна.

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, уурхайчин хамт олон, бизнесийн түнш хамтран ажиллагсдадаа амжилт бүтээлээр арвин, аз хийморior дүүрэн байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ

“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.МЭНДСАЙХАН




## "ШАРЫН ГОЛ" ХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

1. Нэр: "Шарын гол" ХК

   Үндсэн харьяалал: Монгол улс

2. Хаяг: Дархан-Уул аймаг Шарын гол сум Санжинт баг

   Утас: 70372235 Факс: 70372235

3. Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл "Засгийн газрын 2003 оны 162 дугаар тогтоол, төрийн өмчийн хорооны 2003 оны 682 дугаар тогтоолоор 100 хувь, хувийн өмчит компани болсон.

4. Улсын бүргэлийн гэрчилгээний дугаар 1910010009, регистерийн дугаар 2050374

5. Тус компани нь чулуун нүүрс олборлон Дархан, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц болон бусад гэрээт байгууллага, компаниудад нийлүүлдэг.

6. Компанийн эрх барих дээд байгууллага нь: Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ бөгөөд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал удирдана.

**“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн**
**ээлжит хурлын үйл ажиллагааны дараалал**

2023.04.21

| д/д | Үйл ажиллагаа | Хариуцагч |
|---|---|---|
| 1. | Хуралд оролцох хувьцааг бүртгэн нэгтгэж хуралд мэдээлэл бэлтгэх | Тооллогын комисс |
| 2. | Хуралд ирсэн хувьцааны бүртгэлийн дүн бүхий тооллогын комиссын тогтоол танилцуулах | Тооллогын комисс |
| 3. | ХЭ-ийн хурал нээх | Хурлын дарга |
| 4. | ХЭ-ийн хуралд хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулах | Хурлын дарга |
| 5. | Компанийн 2022 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах | Гүйцэтгэх захирал, Ерөнхий инженер |
| 6. | Компанийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлт | Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч |
| 7. | ТУЗ-ийн 2022 оны үйл ажиллагаа, компанийн засаглалын тайлан мэдээлэл | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга |
| 8. | ТУЗ-ийн 2023 оны зардлын төсөв батлах. | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга |
| 14. | Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон ХЭ-ийн асуулт хариулт санал бодол | |
| 15. | Завсарлага, санал тоолж нэгтгэх | Тооллогын комисс |
| 16. | Санал хураалтын дүнг хуралд танилцуулах /тооллогын комиссын тогтоол/ | Тооллогын комисс |
| 17. | ХЭ-ийн хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулж батлуулах | ТУЗ-ийн н/б дарга |
| 18. | Хурал хаах | Хурлын дарга |

ХУРЛЫН ТОВ: 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 15 цагаас

ХУРЛЫН БАЙР: Дархан-Уул аймгийн Шарын гол сумын 3-р баг, Санжинт, Шарын гол ХК-ийн байр 2 давхар хурлын танхим

## ХУРАЛД ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Компанийн 2022 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах.
2. Компанийн ТУЗ-ийн 2023 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох



# НЭГ. КОМПАНИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 1. Үйл ажиллагааны хураангуй:

Компани 2022 онд 9,921.2 мян.м$^3$ хөрс хуулалт хийж, 1,404.7 мян.тн нүүрс олборлож, 1,363.5 мян.тн нүүрс борлуулахаар төлөвлөгөө тавин ажилласан бөгөөд тайлант хугацаанд гүйцэтгэлээр 8,791.3 мян.м$^3$ хөрс хуулалт хийгдэж 1,509.9 мян.тн нүүрс олборлон, 1,509.1 мян.тн нүүрс борлуулсан. 2021 онтой харьцуулахад хөрс хуулалт, нүүрс олборлолт ба борлуулалтын тоо хэмжээ дунджаар 30%-ийн өсөлттэй байгаа болович төлөвлөлтийн хувьд хөрс хуулалт хоцрогдолтой /88,6%/ байна.

Тайлант оны хувьд өмнөх онтой харьцуулахад санхүүгийн болон үндсэн үзүүлэлтүүд сайжирсан он байлаа.

| № | Үзүүлэлт | хэмжих нэгж | 2020 он | | 2021он | | 2022 он | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөвлөгөө | гүйцэтгэл | төлөвлөгөө | гүйцэтгэл | төлөвлөгөө | гүйцэтгэл |
| 1 | Нүүрс олборлолт | мян.тн | 1,009.3 | 996.1 | 1,132.8 | 1,159.1 | 1,404.7 | 1,509.9 |
| 2 | Нүүрс борлуулалт | мян.тн | 1,113.8 | 1,003.3 | 1,124.6 | 1,156.4 | 1,363.5 | 1,509.1 |
| 3 | Хөрс хуулалт | мян.м3 | 10,556.0 | 7,594.8 | 7,190.2 | 6,066.0 | 9,921.2 | 8,791.3 |
| 4 | Уулын цул | мян.м3 | 11,376.5 | 8,361.0 | 8,061.6 | 6,957.6 | 11,001.7 | 9,948.9 |
| 5 | Тэслэгдэх уулын цул | мян.м3 | - | 1,701.0 | 1,359.4 | 388.6 | 3,091.0 | 3,002.3 |
| 6 | Өрөмдсөн уртааш | мян.м | 190.3 | 45.4 | 172.1 | 35.8 | 50,485.0 | 57.2 |




1990 оноос хойш буюу 33 жилийн дараа 2022 онд 1,5сая тн нүүрсийг олборлож борлуулав.







2022 онд компани дараахь техник хэрэгслийг  уулын ажлыг гүйцэтгэхэд ашигласан.

| № | Техникүүд | | Тоо ширхэг |
|---|---|---|---|
| 1 | Гидро экскаватор | экскаватор | 8 |
| 2 | Цахилгаан экскаватор | | 5 |
| 3 | Комацу 465 | дамп өөрөө ачигч | 9 |
| 4 | XEMC 100 | | 4 |
| 5 | Хово371 | | 12 |
| 6 | Хитачи1700 | | 3 |
| 7 | Ковш | авто ачигч | 5 |
| 8 | Грейдер | | 2 |
| 9 | Дозер | трактор | 4 |
| 10 | Өрөм Di550 | | 1 |
| 11 | Бусад | | 20 |
| Нийт | | | 73 |

**Хүний нөөцийн талаар:**

Шарын гол ХК-д 2022 онд 484 ажилтан ажилласан. Үүнээс Инженер техникийн ажилтан 70 албан хаагч 40,  ажилчин 374 байна. Тус онд ажилд орсон 224, ажлаас гарсан 143 ажилтан байна.



Хөдөлмөрийн зохион байгуулалтыг оновчтой хуваарилах, ажилтаны мэдлэг боловсролыг дээшлүүлэх, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, нийгмийн хамгааллыг дээшлүүлэх талаар анхаарч ажиллаж байгаа хэдий ч хүний нөөцийн хувьд тогтвор суурьшилтай ажиллах мэргэжлийн боловсон хүчин дутмаг байна.

Компани нийгмийн хариуцлагын хүрээнд сум орон нутагтай хамтран ажиллаж 278.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн бизнесийг дэмжих хүрээнд 1,119.6 сая төгрөгийн худалдан авалт хийж, хамтран ажилласан.

## 2.Санхүүгийн тайлан:

| | **Балансын зүйл** | **2021 он** | **2022 он** | **зөрүү /сая.төг/** | **эзлэх хувь / 2022 /** |
|---|---|---|---|---|---|
| 1 | *ХӨРӨНГӨ* | | | | |
| 1.1.11 | Эргэлтийн хөрөнгийн дүн | 17,737.4 | 22,621.0 | 4,883.6 | 24.4% |
| 1.2.10 | Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 61,045.6 | 69,907.7 | 8,862.1 | 75.6% |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **78,783.0** | **92,528.7** | **13,745.7** | |
| 2.1 | *ӨР ТӨЛБӨР* | | | | |
| 2.1.1.1 | Богино хугацаат өр төлбөрийн дүн | 32,419.6 | 38,395.6 | 5,975.9 | |
| 2.1.2.6 | Урт хугацаат өр төлбөрийн дүн | 21,120.9 | 25,113.1 | 3,992.2 | |
| 2.2 | Өр төлбөрийн нийт дүн | 53,540.5 | 63,508.6 | 9,968.1 | 68.6% |
| 2.3 | *Эздийн өмч* | | | - | |
| 2.3.11 | Эздийн өмчийн дүн | 25,242.5 | 29,020.1 | 3,777.6 | 31.4% |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **78,783.0** | **92,528.7** | **13,745.7** | |

Компанийн нийт хөрөнгийн 24,4%-ийг эргэлтийн хөрөнгө эзэлж байгаа бөгөөд мөнгөн хөрөнгө өмнөх онтой харьцуулахад 2,446.9 сая.төгрөгөөр буурсан, авлага 5,976.4 сая.төгрөгөөр, бараа материал 849.8 сая.төгрөгөөр, урьдчилж төлсөн зардал тооцоо 504.3 сая төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй гарчээ. Эргэлтийн бус хөрөнгийн эзлэх хувь нь 75.6% байгаа ба өмнөх оныхоос үндсэн хөрөнгө 9,805.4 сая.төгрөгөөр, биет бус хөрөнгө 4.2 сая төгрөгөөр нэмэгдэж, урт хугацаат хөрөнгө орлуулалт 240.8 сая.төгрөгөөр, хайгуул ба үнэлгээний хөрөнгө 278.4 сая төгрөгөөр буурсан.

Нийт өр төлбөрийн 60,5%-ийг богино хугацаат өр төлбөр, 39,5%-ийг урт хугацаат өр төлбөр эзэлж байгаа бөгөөд өмнөх харьцуулахад өсөлттэй байна.

**2022 оны санхүүгийн тайлангийн өөрчлөлтүүд**

**Авлага:**

Компанийн хэмжээнд тайлант оны эхэнд 11,370.3 сая төгрөгийн авлагатай байсан бол оны эцэст 17,346.8 сая төгрөг болж оны эхнээс 5,976.6 сая төгрөгөөр өссөн ба нийт авлагын 59 %-ийг нүүрсний авлага эзэлж байна.

Авлагыг графикаар харуулбал:







- Нийт авлагад нүүрсээр авах авлага 59%-ийг эзэлж байна. Нүүрсний авлага оны эхэнд 7,963.0 сая төгрөг байсан бол оны эцэст 10,243.2 сая төгрөг болж өссөн ба ихэнхи хувийг Дархан ДЦС, Эрдэнэт ДЦС эзэлж байна.
- Нүүрсний авлагын дүнд томоохон жин эзэлж буй компаниудыг графикаар харуулбал:






**Бараа материал**

2022 оны эхэнд бараа материалын үлдэгдэл 3,324.8 сая.төгрөг байсан ба оны эцэст 4,174.6 сая төгрөг болж  оны эхнээс 849.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

| № | Төрөл | эхний үлдэгдэл | орлого | зардал | эцсийн үлдэгдэл | зөрүү |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Түүхий эд материал | 265.3 | 2,590.6 | 2,393.8 | 462.2 | 196.9 |
| 2 | Бэлэн бүтээгдэхүүн | 770.1 | 66,950.4 | 66,909.4 | 811.2 | 41.1 |
| 3 | Хангамжийн материал | 137.8 | 1,364.7 | 1,342.4 | 160.1 | 22.3 |
| 4 | Түлш | 47.7 | 21,771.0 | 21,783.2 | 35.5 | (12.2) |
| 5 | Тос тослох материал | 399.4 | 1,393.6 | 1,677.8 | 115.1 | (284.3) |
| 6 | Сэлбэг материал | 1,631.5 | 10,531.9 | 9,640.4 | 2,523.0 | 891.5 |
| 7 | Хөдөлмөр хамгаалал | 73.0 | 381.6 | 387.0 | 67.6 | (5.4) |
| | **Нийт** | **3,324.8** | **104,983.8** | **104,134.0** | **4,174.6** | **849.8** |

**Үндсэн хөрөнгө:**

Компани үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж , машин механизмыг өрнөж байгаа  уулын ажил, өсөн нэмэгдэж байгаа нүүрс олборлолт ба борлуулалттай  уялдуулан  шинэчлэх бодлого баримталж ажиллаж ирсэн бөгөөд үүнтэй холбоотойгоор тайлант онд 18,031.2сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар дараахь техникүүдийг худалдан авсан.Үүнд:

| № | Хөрөнгийн нэр | тоо ширхэг | сая.төг | Эх үүсвэр | зориулалт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Экскаватор /EX1200-7BH/ | 1 | 3,421.28 | лизингээр худалдан авсан | хөрс , нүүрс хуулах |
| 2 | Эскаватор R520LC-9S #1326 | 1 | 987.2 | | хөрс , нүүрс хуулах |
| 3 | Хүнд даацын автомашин-Komatsu Dump 465 | 4 | 5,968.2 | | хөрс , нүүрс тээвэрлэх |
| 4 | Автосамсовал /Hitachi Eh1700-3/ | 3 | 6,420.0 | | хөрс тээвэрлэх |
| 5 | Sinotruck Howo 371 №107 | 1 | 90.0 | | уурхайн карьерийн талбай услах |
| 6 | Автокран /Zoomlion QY25H-QY25v531/ | 1 | 159.5 | өөрийн хөрөнгөөр худалдан авсан | ачаа тээш өргөх |
| 7 | Автобус /Aerocity hyundai 540/ | 1 | 90.0 | | ажилчид тээвэрлэх |
| 8 | Бага оврын автобус /Toyota Hiace/ | 1 | 66.5 | | ХХХ-д |
| 9 | Суудлын авто машин /Land Cruiser 76 / | 1 | 130.8 | | |
| 10 | Автомашин RAM REBEL 1500 | 1 | 243.9 | | |
| 11 | Ачааны машин /Hyundai Porter-2/ | 1 | 42.4 | | |
| 12 | Бусад | | 131.9 | | |
| | **Дүн** | **16** | **18,031.2** | | |

**Өр төлбөр:**

2022 оны эцэст нийт өр төлбөрийн 60,5 %-ийг богино хугацаат өр  төлбөр , 39,5 %-ийг урт хугацаат өр төлбөр эзэлж байна. Нийт өр төлбөр 9,968.1 сая төгрөгөөр нэмэгджээ.

**Богино хугацаат өр төлбөр:**

- **Дансны өглөг:** Богино хугацаат өр төлбөр оны эхнээс 5,975.9 сая төгрөгөөр өссөн  үзүүлэлттэй байна.Үүнд дансны өглөг 3,472.3 сая.төгрөгөөр, урьдчилж орсон орлого 3,103.9 сая төгрөгөөр, татварын өр 1,087.2 сая төгрөгөөр, бусад богино хугацаат өр төлбөр 10,357.6 сая.төгрөгөөр

нэмэгдэж,харин богино хугацаат зээлийн өглөг 12,313.4 сая.төгрөгөөр буурч үлдэгдэлгүй болсон байна.

Томоохон өглөгүүдийг байгууллагаар нь жагсаавал:

Баодинг эрээн хот -д нүүрсний өглөг 3,519.6 сая төгрөг
МН жойн ХХК-д тэсрэх материалын төлбөрт 297.0 сая төгрөг
Собу петро ХХК-д түшний төлбөрт 3,200.5 сая төгрөг
Солонго эксим ХХК-д сэлбэгийн төлбөрт 200.0 сая төгрөг
Ти Ди Би лизинг ХХК-д санхүүгийн түрээс 6,376.2 сая төгрөг

- Богино хугацаат зээл ба зээлийн хүүгийн төлбөрийн хэмжээ буурсан.




Компани 2022 оны тайлант хугацаанд 8,921.3 сая төгрөгийн татвар болон НДШ ногдуулж 7,6 тэрбум төгрөгний татварт 5199,8сая төгрөг НДШимтгэлд 2535,4сая төгрөгийг төлжээ.




**Урт хугацаат өр төлбөр :**

Урт хугацаат өр төлбөр нь оны эхэнд 21,120.9 сая төгрөг байсан ба оны эцэст 25,113.1 сая төгрөг болж 3,992.2 сая төгрөгөөөр өссөн.Үүнд: урт хугацаат өр төлбөр буюу Ти Ди Би лизинг ба Солонго эксим ХХК-с авсан санхүүгийн түрээсийн өглөг /4,612.1 сая төгрөг/ хамаарч байна.

**3.Мөнгөн гүйлгээний тайлан:**

| | Үзүүлэлт | 2021 он | 2022 он | зөрүү /сая.төг/ |
|---|---|---|---|---|
| 1 | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **11,426.8** | **15,969.5** | **4,542.7** |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 63,784.0 | 83,404.9 | 19,620.9 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 52,357.2 | 67,435.3 | 15,078.1 |
| 2 | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **(2,544.9)** | **(2,854.2)** | **(309.3)** |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 63.6 | 9.2 | (54.4) |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 2,608.5 | 2,863.4 | 254.9 |
| 3 | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **(8,781.2)** | **(15,385.2)** | **(6,604.0)** |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 3,800.0 | 250.0 | (3,550.0) |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 12,581.2 | 15,635.2 | 3,054.0 |
| 4 | *Валютын ханшийн зөрүү* | **-** | **(177.0)** | **(177.0)** |
| 4.1 | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **100.7** | **(2,446.9)** | **(2,547.6)** |
| 5 | **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **3,383.7** | **3,484.4** | **100.7** |
| 6 | **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **3,484.4** | **1,037.4** | **(2,446.9)** |

Тайлант хугацаанд нийт орлогын 84,2%-ийг нүүрсний борлуулалтаас /70,216.4 сая.төгрөг/, 12.5%-ийг алтны борлуулалтаас /10,078.1 ся.төгрөг/ орлого олсон байна. 2022 оны үйл ажиллагааны мөнгөн хөрөнгөний зарцуулалтын 11,1%-ийг ажилчдад /цалин,тэтгэмж г.м/, түлш шатахуун,тосны зардал 25,9%-ийг, тэсрэх материалын зардалд 3,0%-ийг, сэлбэг материал худалдан авахад 12.1%-ийг, үлдсэнийг бусад зардалд зарцуулсан байна.

### 4.Орлогын дэлгэрэнгүй тайлан:

| № | Үзүүлэлт | 2021 он | 2022 он | зөрүү /сая.төг/ |
|---|---|---|---|---|
| **1** | **Борлуулалтын орлого ( цэвэр )** | **64,277.3** | **80,294.5** | **16,017.2** |
| 2 | Борлуулалтын өртөг | 55,912.1 | 74,141.7 | 18,229.6 |
| **3** | **Нийт ашиг ( алдагдал )** | **8,365.2** | **6,152.8** | **(2,212.3)** |
| 4 | Бусад орлого | 1,498.2 | 4,817.3 | 3,319.1 |
| 5 | Борлуулалт, маркетингийн зардал | 272.5 | 678.8 | 406.3 |
| 6 | Ерөнхий ба удирдлагын зардал | 1,703.7 | 1,989.3 | 285.6 |
| 7 | Санхүүгийн зардал | 1,653.7 | 2,486.4 | 832.7 |
| 8 | Бусад зардал | 1,826.5 | 2,714.1 | 887.6 |
| 9 | Бусад олз ( гарз ) | 456.9 | (1,232.7) | |
| **10** | **Татвар төлөхийн өмнөх ашиг ( алдагдал )** | **4,863.8** | **1,868.8** | **(2,995.0)** |
| 11 | Орлогын татварын зардал | 402.0 | 351.4 | (50.6) |
| **12** | **Татварын дараах ашиг ( алдагдал )** | **4,461.8** | **1,517.4** | **(2,944.4)** |
| **13** | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал )** | **4,461.8** | **1,517.5** | **(2,944.4)** |

### Нүүрсний өртөг ба борлуулалтын дундаж үнэ

- Эрчим хүчний зориулалттай нүүрсний үнийг нэмэгдүүлэх талаар удаа дараа хүсэлт, албан бичиг илгээсний үр дүнд 2022 оны 11 сарын 25-ны №587 дугаар тогтоолын дагуу нүүрсний үнийг 52,740 төгрөг болгон нэмэгдүүлсэн. /18,5%-иар нэмэгдсэн/
- 1 тн нүүрсний өртөг 7,380.6 төгрөгөөр нэмэгдсэн. Зардал нийтдээ өсөлттэй байгаа бөгөөд голлон тэсэлгээний материал, түлш ба өтгөн тосны зардал , бусдаар гүйцэтгүүлсэн ажлын зардал илүүтэй нэмэгдсэн.

| Зардал | 2021 он | | 2022 он | | зөрүү | өсөлт % |
|---|---|---|---|---|---|---|
| | сая.төг | эзлэх хувь | сая.төг | эзлэх хув | | |
| Тэсэлгээний материал | 646.78 | 1.4% | 2,393.76 | 3.3% | 1,749.68 | 270.1% |
| Түлш | 7,040.83 | 15.0% | 20,939.89 | 29.0% | 13,899.06 | 197.4% |
| Өтгөн тос | 937.91 | 2.0% | 1,624.17 | 2.3% | 686.26 | 73.2% |
| Цахилгаан | 1,704.96 | 3.6% | 1,860.16 | 2.6% | 155.21 | 9.1% |
| Цалин хөлс | 6,623.85 | 14.2% | 9,115.37 | 12.6% | 2,491.52 | 37.6% |
| НДШ | 821.62 | 1.8% | 1,290.52 | 1.8% | 468.90 | 57.1% |
| ҮХЭлэгдэл | 8,506.72 | 18.2% | 8,712.00 | 12.1% | 205.29 | 2.4% |
| Сэлбэг материал | 9,073.48 | 19.4% | 9,878.89 | 13.7% | 805.41 | 8.9% |
| Дулаан | 644.51 | 1.4% | 850.78 | 1.2% | 206.27 | 32.0% |
| Харуул хамгаалалт | 574.84 | 1.2% | 828.35 | 1.1% | 253.52 | 44.1% |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил | 2,014.91 | 4.3% | 3,961.62 | 5.5% | 1,946.71 | 96.6% |
| Татвар | 334.74 | 0.7% | 529.74 | 0.7% | 195.00 | 58.3% |
| Хүүгийн зардал | 1,653.74 | 3.5% | 2,486.40 | 3.4% | 832.66 | 50.4% |
| Хөдөлмөр хамгаалал | 478.88 | 1.0% | 532.02 | 0.7% | 53.14 | 11.1% |
| Түрээсийн зардал | 2,802.55 | 6.0% | 3,749.03 | 5.2% | 946.48 | 33.8% |
| Бусад | 519.76 | 1.1% | 684.10 | 0.9% | 164.34 | 31.6% |
| Удирдлага,борлуулалтын зардал | 2,415.43 | 5.2% | 2,668.08 | 3.7% | 252.65 | 10.5% |
| | 46,795.52 | | 72,104.90 | | 25,309.38 | 54.1% |
| 1 тн нүүрсний өртөг | **40,373.85** | | **47,754.40** | | | |
| 1 тн нүүрсний борлуулалтын үнэ | **46,630.70** | | **46,529.30** | | | |

**Ашиг алдагдал:**

**Борлуулалтын орлого:**

Компани тайлант онд 85,208.9 сая төгрөгийн борлуулалт хийснээс нүүрсний борлуулалтаас 82,4 %, алтны борлуулалтаас 11,8% , сэлбэг борлуулсанаас 1,0%, хаягдал төмөр борлуулсанаас 0,5%, бусад борлуулалтаас 4,2%- ийг олж 1,5 тэрбум төгрөгний ашигтай ажилласан.

Орлогыг төрлөөр нь авч үзвэл :

| № | Орлогын нэр төрөл | 2021 он | | 2022 он | | Зөрүү |
|---|---|---|---|---|---|---|
| | | сая.төг | хувь | сая.төг | хувь | сая.төг |
| 1 | Нүүрсний орлого | 53,921.8 | 79.7% | 70,216.4 | 84.2% | 16,294.7 |
| 2 | Алтны орлого | 10,355.5 | 15.3% | 10,078.1 | 12.1% | (277.4) |
| 3 | Үйлдвэрийн бус орлого | 12.1 | 0.0% | 15.1 | 0.0% | 3.0 |
| 4 | Сэлбэг борлуулсан орлого | 136.7 | 0.2% | 818.7 | 1.0% | 682.0 |
| 5 | Хаягдал төмөр борлуулсан орлого | 14.9 | 0.0% | 397.0 | 0.5% | 382.2 |
| 6 | Валютын ханш | 758.1 | 1.1% | 88.6 | 0.1% | (669.4) |
| 7 | Бусад | 2,448.6 | 3.6% | 1,800.3 | 2.2% | (648.3) |
| | **НИЙТ** | **67,647.6** | | **83,414.3** | | **15,766.7** |

Тайлант хугацаанд орлого өмнөх оныхоос 28,0%-иар буюу 18,644.0 сая төгрөгөөр өсөхөд дараахь хүчин зүйл нөлөөлсөн.Үүнд:

- Борлуулалтын биет хэмжээ 353.7 мян.тн-оор нэмэгдсэнээр нүүрсний борлуулалтын орлого 16,294.7 сая.төгрөгөөр нэмэгдсэн.
- Хүнд машин механизм, цахилгаан тоноглол зэргийг түрээслүүлэн 3,052.5 сая төгрөгийн орлого олсон.

**Зардал:**

Компани тайлант онд 83,691.4 сая төгрөгийн зардал гаргаж ажилласанаас нүүрс олборлох үйл ажиллагаанд 83,8%-ийг, алт олборлох үйл ажиллагаанд 4,8%-ийг зарцуулсан ба зардлын төрлөөр нь авч үзвэл:

| № | Зардалын төрөл | 2021 он | 2022 он | өөрчлөлт | хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Тэсэлгээний зардал | 646.8 | 2,393.8 | 1,746.97 | 270.1% |
| 2 | Тос тосолгооны материал | 937.9 | 1,624.2 | 686.26 | 73.2% |
| 3 | Цалин хөлс | 6,623.9 | 9,110.2 | 2,486.35 | 37.5% |
| 4 | Түлш шатахуун | 7,040.8 | 20,940.9 | 13,900.04 | 197.4% |
| 5 | НДШ | 821.6 | 1,289.7 | 468.09 | 57.0% |
| 6 | ҮХЭлэгдэл | 8,506.7 | 8,712.0 | 205.24 | 2.4% |
| 7 | Сэлбэг материал | 10,046.7 | 9,855.7 | (191.03) | -1.9% |
| 8 | Уур дулаан | 68.9 | 63.8 | (5.09) | -7.4% |
| 9 | Түрээс | 2,802.6 | 3,749.0 | 946.48 | 33.8% |
| 10 | Бусад | 2,891.7 | 2,731.1 | (160.57) | -5.6% |
| | **НИЙТ** | **40,387.6** | **60,470.3** | **20,082.74** | **49.7%** |

## ХОЁР. 2022 ОНЫ ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН /ХУРААНГУЙ/

“ПАНТЕР МИДЛАНД АУДИТ” ХХК

# “ШАРЫН ГОЛ” ХК

## 2022 оны 12 сарын 31-нээр дуусгавар болгосон аудитын тайлан

Улаанбаатар хот

2023 он

# "ШАРЫН ГОЛ" ХК-ИЙН
# 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

АГУУЛГА ХУУДАС


Хараат бус аудиторын тайлан ........ 2-4

Санхүүгийн байдлын тайлан ........ 5

Орлогын тайлан ........ 6

Мөнгөн гүйлгээний тайлан ........ 7

Өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 8

Санхүүгийн тайлангийн тодруулга, компанийн товч мэдээлэл, танилцуулга ........ 9-11

Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй ........ 12-21

Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 22-36

Актуарчийн тайлан хавсралтаар........ 37-39


**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу**


Гүйцэтгэх захирал Ц.Алтанцэцэг
Утас: 976-7013-1770
Гар утас: 9511-1770

Аудитор Ц.Алтанцэцэг
Гар утас: 9511-1770
Туслах аудитор Т.Мөнхцацрал
Гар утас: 97111770

Чанарын хяналтын аудитор
Б.Бямбасүрэн
Гар утас: 99184746
Б.Сансармаа
Гар утас: 91006906

Аудиторын туслах Г.Чулуунчимэг
Н.Гэрэлцэцэг
С.Алтантуяа
О.Анар

"Пантер мидланд аудит" ХХК
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Нарны зам 81, JS tower 1002 тоот
e-mail: info@pma.mn
fax: 976-7014-1770

**Вэб хуудас:** www.pma.mn


2023 оны 02 дугаар сарын 27

PANTHER MIDLAND AUDIT LLC
AUTHORIZED EXPERTS IN ACCOUNTING, AUDIT, CONSULTATION AND ASSESSMENT

Хаяг: JS Tower 10-р давхар - 1002 тоот - Сүхбаатар дүүрэг 5-р хороо Нарны зам Улаанбаатар хот, Монгол улс
Утас:(976) 7013 1770
Факс:(976) 7014 1770

Огноо: 2023. 02. 28.    № 23/10

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### "ШАРЫН ГОЛ" ХК-ИЙН УДИРДЛАГАД

**Зөрчилгүй дүгнэлт**

Бид "Шарын гол" ХК ('Компани' гэх)-ийн 2022 оны 12 сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангүйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Компанийн 2022 оны 12 сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

Энэхүү дүгнэлт нь хавсаргасан санхүүгийн тайлангууд болон 9-35 хүртэлх хуудсан дахь тэмдэглэлийн хамтаар хүчин төгөлдөр болно.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)- өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

**Аудитын гол асуудлууд**

***Уурхайн хөрөнгийн дансны үнэ ба олборлолтын өртөг:***

Бид 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх нүүрсний агууламж, түвшин болон нягтралын талаарх мэдээллийг ТЭЗҮ дэх мэдээлэлтэй тулгаж шалгасан.

ТЭЗҮ боловсруулахад удирдлагын ашигласан өгөгдлүүд, мэргэжлийн ур чадвар болон бодитой байдлыг үнэлсэн. Тайлант жилийн турш капиталжуулсан зарцуулалтуудын дэлгэрэнгүй тест гүйцэтгэж, тухайн зарцуулалтуудын үнэн зөв, иж бүрэн байдлыг үнэлсэн.

Мөн бид бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийн тесттэй холбоотойгоор ирээдүйн нүүрсний үнийг харьцуулж, зах зээлийн хандлагыг харгалзан үзсэн. Мөн уурхайн хөрөнгөтэй холбоотой үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрхийлсэн аливаа зүйл байхгүй талаарх удирдлагын үнэлгээг чухалчлан авч үзсэн.

***Нөхөн сэргээлтийн нөөц:***

Бид ирээдүйн зардлын төлөвлөгөө, өртгийн загварыг бэлтгэхэд удирдлагын ашигласан мэргэжлийн ур чадвар, бодитой байдлыг үнэлсэн. Бид уурхайн зардлын төлөвлөгөө, зардлын загварчлалыг үнэлсэн бөгөөд уг загварчлал дахь гол тооцоолол болон төсөөллийг үнэлсэн. Түүнчлэн бид нөхөн сэргээлтийн хүлээгдэж буй хугацааг уурхайн ашиглалтын хугацаанд тооцоолж, хүлээгдэж байгаа мөнгөн урсгалд ашигласан дискаунтын түвшнийг үнэлсэн.

***Ажилчдын тэтгэврийн сангийн нөөц:***

Бид аудитын явцад хөндлөнгийн актуарчийг аудиторын шинжээчээр ажиллуулж, тэтгэмжийн сангийн тооцоолoлтой холбоотойгоор удирдлагын ашигласан мэргэжлийн ур чадвар, тооцооллын бодитой байдлыг үнэлсэн. Үүнд хүлээгдэж буй мөнгөн урсгал, хүлээгдэж буй буй мөнгөн урсгалын хуваарилалт, зохистой дискаунтын түвшин зэргийг үнэлсэн. Энэхүү аудиторын шинжээчийн ажилд суурилан бид удирдлагын тооцооллыг ул үндэслэлтэй гэж үнэлсэн.

**Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь СТОУС-уудын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

**Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу бид аудитын хэсэг болгон мэргэжлийн үнэлэмж ашиглаж, аудитын турш мэргэжлийн үл итгэх байр суурийг баримталдаг. Түүнчлэн бид:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл ойшоох явдлууд багтсан байж болно.
- Нягтланд бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ болон хугацаа, аудитын томоохон илрүүлэлт, аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын томоохон дутагдал болон холбогдох бусад асуудлаар засаглах удирдлагатай харилцдаг.

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Монгол Улсын "Компанийн тухай хууль" -ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох "Шарын гол" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

**"Пантер Мидланд Аудит" ХХК**
Гүйцэтгэх захирал Ц.Алтанцэцэг

## АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

**"ШАРЫН ГОЛ" ХК**
(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | 1/1/2022 | 12/31/2022 |
|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 3,484,362,024.83 | 1,037,415,501.08 |
| Дансны авлага | 6,725,169,094.72 | 9,306,332,560.91 |
| Татвар, НДШ-ийн авлага | 0.00 | 0.00 |
| Бусад авлага | 998,382,354.30 | 4,394,661,259.34 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 0.00 | 0.00 |
| Бараа материал | 3,324,817,335.36 | 4,174,611,653.82 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 3,204,677,466.33 | 3,709,014,274.39 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **17,737,408,275.54** | **22,621,035,249.54** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө | 39,569,547,783.17 | 48,654,945,253.68 |
| Биет бус хөрөнгө | 522,329.46 | 4,733,156.03 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 1,407,680,889.50 | 1,166,870,483.73 |
| Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | 2,540,050,970.89 | 2,261,611,188.24 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 254,021,489.12 | 254,021,489.12 |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | 17,273,732,214.10 | 17,565,489,962.60 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **61,045,555,676.24** | **69,907,671,533.40** |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **78,782,963,951.78** | **92,528,706,782.94** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **Өр төлбөр** | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | |
| Дансны өглөг | 8,408,436,225.53 | 11,880,753,807.38 |
| Цалингийн өглөг | 287,463,725.00 | 515,870,484.00 |
| Татварын өр | 6,273,206,745.26 | 7,360,413,237.00 |
| НДШ-ийн өглөг | 139,864,693.00 | 238,742,798.75 |
| Богино хугацаат зээл | 12,313,440,128.30 | 0.00 |
| Хүүгийн өглөг | 571,023,150.23 | 554,696,209.24 |
| Ногдол ашгийн өглөг | 376,142.95 | 376,142.95 |
| Урьдчилж орсон орлого | 804,501,580.02 | 3,908,402,174.80 |
| Нөөц/өр төлбөр/ | 42,619,945.00 | 0.00 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 3,578,689,615.97 | 13,936,303,955.68 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **32,419,621,951.26** | **38,395,557,809.80** |
| **Урт хугацаат өр төлбөр** | | |
| Нөөц/өр төлбөр/ | 14,061,602,995.08 | 13,441,710,995.08 |
| Хойшлогдсон татварын өр | 96,007,802.03 | 96,007,802.03 |
| Бусад урт хугацаат өр төлбөр | 6,963,258,452.43 | 11,575,339,179.67 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **21,120,869,249.54** | **25,113,057,976.78** |
| **Өр төлбөрийн нийт дүн** | **53,540,491,200.80** | **63,508,615,786.58** |
| **Эздийн өмч** | | |
| Өмч - төрийн | 0.00 | 0.00 |
| - хувьцаат | 1,017,024,200.00 | 1,242,382,500.00 |
| Нэмж төлөгдсөн капитал | 23,145,157,851.13 | 25,179,951,797.40 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 16,744,190,196.39 | 16,590,507,978.69 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | (15,663,899,496.54) | (13,992,751,279.73) |
| **Эздийн өмчийн дүн** | **25,242,472,750.98** | **29,020,090,996.36** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **78,782,963,951.78** | **92,528,706,782.94** |

*9-38 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн*

ШАРЫН ГОЛ

## АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

**"ШАРЫН ГОЛ" ХК**
(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | 1/1/2022 | 12/31/2022 |
|---|---|---|
| **Борлуулалтын орлого (цэвэр)** | **64,277,300,474.65** | **80,294,549,175.95** |
| Борлуулалтын өртөг | 55,912,124,428.74 | 74,141,714,971.52 |
| **Нийт ашиг (алдагдал)** | **8,365,176,045.91** | **6,152,834,204.43** |
| Түрээсийн орлого | 1,237,580,453.78 | 3,052,512,604.77 |
| Хүүний орлого | 1,777,455.23 | 0.00 |
| Ногдол ашгийн орлого | 0.00 | 0.00 |
| Эрхийн шимтгэлийн орлого | 0.00 | 0.00 |
| Бусад орлого | 258,835,941.45 | 1,764,772,306.69 |
| Борлуулалт маркетингийн зардал | 272,539,473.54 | 678,822,298.86 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 1,703,677,158.64 | 1,989,257,117.48 |
| Санхүүгийн зардал | 1,653,739,478.83 | 2,486,399,032.82 |
| Бусад зардал | 1,826,499,865.01 | 2,714,106,223.80 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 658,897,146.41 | (1,236,477,087.02) |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | (201,990,548.81) | 3,802,741.85 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **4,863,820,517.95** | **1,868,860,097.76** |
| Орлогын татварын зардал | 401,986,871.37 | 351,394,098.65 |
| **Татварын дараах ашиг (алдагдал)** | **4,461,833,646.58** | **1,517,465,999.11** |
| Зогсоон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал) | | |
| **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **4,461,833,646.58** | **1,517,465,999.11** |
| **Бусад дэлгэрэнгүй орлого** | **0.00** | **0.00** |
| Хөрөнгө дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | 0.00 | 0.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 |
| Бусад олз (гарз) | 0.00 | 0.00 |
| **Орлогын нийт дүн** | **4,461,833,646.58** | **1,517,465,999.11** |
| Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | - | - |

*9-36 дугаар хуудсан дахь тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн*

## АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**"ШАРЫН ГОЛ" ХК**
(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр) (төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | **63,783,996,490.04** | **83,404,864,665.04** |
| Борлуулсан, үзүүлсэн үйлчилгээний орлого | 63,260,133,984.94 | 82,743,483,513.46 |
| Эрхийн шимтгэл, хураамж төлбөрийн орлого | 0.00 | 0.00 |
| Даатгалын нөхөвөрөөс хүлээн авсан мөнгө | 9,766,965.60 | 3,729,832.20 |
| Бусад мөнгөн орлого | 514,095,539.50 | 657,651,319.38 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | **52,357,220,146.32** | **67,435,348,467.24** |
| Ажилчдад төлсөн | 6,772,515,700.22 | 9,515,821,944.81 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 1,824,182,199.00 | 1,755,159,722.67 |
| Бараа материал худалдан авахад төлсөн | 2,930,045,952.81 | 2,689,507,706.27 |
| Ашиглалтын зардалд төлсөн | 192,018,328.00 | 35,223,325.21 |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 19,609,511,512.39 | 35,197,006,951.47 |
| Хүүний төлбөрт төлсөн | 1,548,680,148.36 | 1,812,822,542.59 |
| Татварын байгууллагад төлсөн | 4,358,142,586.47 | 4,167,453,097.33 |
| Даатгалын төлбөрт төлсөн | 95,806,593.85 | 314,211,338.28 |
| Бусад мөнгөн зарлага | 15,026,317,125.22 | 11,948,141,838.61 |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **11,426,776,343.72** | **15,969,516,197.80** |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | **63,622,815.23** | **9,200,000.00** |
| Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого | 61,845,360.00 | 9,200,000.00 |
| Хүлээн авсан хүүний орлого | 1,777,455.23 | 0.00 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | **2,608,541,956.00** | **2,863,442,626.00** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 2,608,541,956.00 | 2,863,442,626.00 |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 0.00 |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн** | **(2,544,919,140.77)** | **(2,854,242,626.00)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | **3,800,003,516.38** | **250,000,000.00** |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 3,800,000,000.00 | 250,000,000.00 |
| Ханшийн тэгшитгэлийн ашиг | 3,516.38 | 0.00 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | **12,581,187,827.44** | **15,812,220,095.55** |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | 8,914,711,015.60 | 10,888,480,469.61 |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | 3,594,345,989.09 | 4,746,727,604.49 |
| Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн | 0.00 | 0.00 |
| Ханшийн тэгшитгэлийн алдагдал | 72,130,822.75 | 177,012,021.45 |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн** | **(8,781,184,311.06)** | **(15,562,220,095.55)** |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **100,672,891.89** | **(2,446,946,523.75)** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **3,383,689,132.94** | **3,484,362,024.83** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **3,484,362,024.83** | **1,037,415,501.08** |

*9-36 дугаар хуудсан дахь тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн.*

## АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

**"ШАРЫН ГОЛ" ХК**
(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмч | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг (алдагдал) | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **1,017,024,200.00** | **23,145,157,851.13** | **16,906,027,807.97** | **(21,538,032,529.47)** | **19,530,177,329.63** |
| **Залруулсан үлдэгдэл** | **1,017,024,200.00** | **23,145,157,851.13** | **16,906,027,807.97** | **(21,538,032,529.47)** | **15,338,358,299.15** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | 0.00 | 4,461,833,646.58 | **4,461,833,646.58** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 0.00 | 0.00 | 0.00 | 1,250,461,774.77 | **1,250,461,774.77** |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.00 | 0.00 | (161,837,611.58) | 161,837,611.58 | **0.00** |
| **2021оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **1,017,024,200.00** | **23,145,157,851.13** | **16,744,190,196.39** | **(15,663,899,496.54)** | **25,242,472,750.98** |
| **Залруулсан үлдэгдэл** | **1,017,024,200.00** | **0.00** | **0.00** | **(15,663,899,496.54)** | **(14,646,875,296.54)** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0.00 | 0.00 | 0.00 | 1,517,465,999.11 | **1,517,465,999.11** |
| Өмчид гарсан өөрчлөлт | 225,358,300.00 | 2,034,793,946.27 | 0.00 | 0.00 | **2,260,152,246.27** |
| Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0.00 | 0.00 | (153,682,217.70) | 153,682,217.70 | **0.00** |
| **2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **1,242,382,500.00** | **25,179,951,797.40** | **16,590,507,978.69** | **(13,992,751,279.73)** | **29,020,090,996.36** |

*9-36 дугаар хуудсан дахь тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн.*

## ГУРАВ. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон бусад эрх зүйн актуудыг удирдлага болгон ажиллаж, компанийн ойрын болон хэтийн төлөвийг тодорхойлон шийдвэр гаргах, үйл ажиллагааг нь хянах зэргээр бүрэн эрхийнхээ хүрээнд тогтвортой, тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирлээ. Үүнд:

### НЭГ. МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Мэдээ мэдээлэл нь тухайн тайлант хугацааны бүхий л үйл ажиллагааг ил тод, нээлттэй байх үндсэн зарчмын илэрхийлэл юм. Тайлант хугацаанд ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан:

- ✓ Компанийн хууль, дүрэм болон бусад засаглалтай холбогдсон үйл ажиллагааны журмууд.
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит, ээлжит бус хурлын тов, хуралд хэлэлцэх асуудал, бүртгэлийн өдөр, хувьцаа эзэмшигчдийн санал авах хуудас, танилцах материалын жагсаалт зэргийг хууль дүрмийн дагуу өдөр тутмын сонин хэвлэлд 2 удаа, телевиз болон бусад мэдээлэх хэрэгслээр, хувьцаа эзэмшигчдийн хуралд хувьцаа эзэмшигчдийг өргөнөөр оролцуулахаар мэдээлж байлаа.
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит, ээлжит бус хурлын бэлтгэл ажлын графикийн дагуу хийсэн ажлын гүйцэтгэлийг уг хуралд мэдээлсэн.
- ✓ Хувьцаа эзэмшигчдэд танилцуулах зорилгоор компанийн хувьцааны 5 хувиас дээш багцыг эзэмшигчид, компанийн жилийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлан, санхүүгийн аудитлагдсан тайлан, ТУЗ-ийн үйл ажиллагаа, засаглалын тайлан зэргийг танилцуулж байлаа.
- ✓ Компанийн 2022 оны 4-р сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагаа, шийдвэрийн талаарх мэдээллийг зохих журмаар мэдээлж байв.
- ✓ Мөн тайлант жилд ажилласан эрх бүхий албан тушаалтнуудын талаарх зураг бүхий мэдээлэл.
- ✓ Компанийн хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл компанийн ТУЗ-д сонгогдон ажиллаж байгаатай холбогдуулан ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төслийг урьдчилан хүргүүлж тэдний санал зөвлөмжийг нь шийдвэрт тусган түүнийг хэрэгжүүлж байдаг юм.

## ХОЁР. ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ-КОМПАНИЙН ХУВЬЦАА

Компанийн хувьцааны 5 хувиас дээш багцыг эзэмшигчид

Нийт хувьцаа 12,423,825

| Д/Д | Хувьцаа эзэмшигчид | Хувьцааны тоо | Эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1. | SHG HOLDINGS 3 | 2,011,744 | 16.1 |
| 2. | SHG HOLDINGS 2 | 2,028,906 | 16.3 |
| 3. | NIHAN HOLDINGS | 1,598,889 | 12.8 |
| 4. | ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК | 1,158,520 | 9.3 |
| 5. | SHG HOLDINGS 1 | 1,142,674 | 9.1 |
| 6. | “ХАЙ БИ ОЙЛ” ХК | 2,253,583 | 18.1 |
| 7. | “ТӨГӨЛДӨР МЕГАМИНКС” ХХК | 1,019,550 | 8.2 |
| | ДҮН | 11,213,866 | 90.2 |

Компанийн нийт хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийг дээрх хүснэгтээр үзүүлэв.

## ГУРАВ. КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Тус компани нь компанийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн хурлыг КТХ-ийн дагуу жил бүрийн 4 дүгээр сард зарлан хуралдуулдаг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр 13 цагаас хуралдуулсан.

Энэхүү хуралд:

- ✓ Компанийн 2021 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх батлах. Компанийн ТУЗ-ийн ажил, засаглалын талаарх мэдээлэл.

- ✓ Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах.
- ✓ Компанийн ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл зэргийг хэлэлцэж шийдвэр гаргасан байна.

## ДӨРӨВ. КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ирлээ. Төлөөлөн удирдах зөвлөл нь тайлант хугацаанд ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүнтэйгээр ажилласан.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2022 онд төлөвлөсөн болон цаг хугацааны асуудлаар хэлэлцэх асуудлыг тухай бүрд нь хэлэлцэж зохих шийдвэрийг гаргаж байлаа. Хуралд гишүүдийг бүрэн оролцуулахын тулд, зарим гишүүдийн орон зайгаас шалтгаалан зарим хурлыг онлайн хэлбэрээр хуралдаж байв.

2022 онд ТУЗ-ийн хурлын тогтоол гаргасан. Үүнд:

- Аудитын компани сонгон, гэрээ байгуулах
- Зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- Ногдол ашиг хуваарилах эсэх тухай тухай
- Компанийн гүйцэтгэх захирлыг чөлөөлөх болон томилох тухай
- Зөвшөөрөл болон эрх олгох тухай Зээл авахыг зөвшөөрөх тухай
- 2021 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт гаргах тухай
- Нүүрсний үнийн тухай зэрэг тогтоолуудыг тус тус гаргасан байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаандаа компанийн засаглалын кодекс, зарчмыг мөрдлөг болгон компанийн засаглалын хөгжлийг манлайлагчдын эгнээнд багтаж ажиллахыг зорин ажиллаж байгаа билээ.

Төсөл

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН**
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН**
**ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 4 сарын 21 дугаар 01 Улаанбаатар

Компанийн жилийн үйл ажиллагааны болон
Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн
удирдах зөвлөлийн дүгнэлтийн тухай

“Шарын гол” хувьцаат компанийн 2022 оны жилийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцээд,

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Шарын гол” хувьцаат компанийн 2022 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ХУЛАН

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН**
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН**
**ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 4 сарын 21 дугаар 02 Улаанбаатар

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны цалин урамшуулал, зардлын төсөв
батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны цалин урамшуулал, зардлын төсвийг /хавсралтаар/ баталсугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ХУЛАН

2023 оны 4-р сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн
хурлын ...дугаартай тогтоолын Хавсралт

**Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсөв**

| д/д | Зардлын төрөл | НИЙТ ЗАРДАЛ төгрөгөөр |
|---|---|---|
| 1 | ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин | 184,380,000 |
| 2 | Нийгмийн даатгалын шимтгэл | 25,919,340 |
| 3 | Үндсэн хөрөнгийн элэгдэл | 33,942,101.90 |
| 4 | Хурлын үйл ажиллагааны бусад зардал | 7,500,000 |
| | **Нийт** | **251,741,441** |

**---o0o---**

## “ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДЭД НЭР ДЭВШИГЧДИЙН ТАНИЛЦУУЛГА

**Ердийн гишүүнд нэр дэвшигчид**



**Бадангийн Батбаатар**

- 1977 Варшав хотод төрсөн
- 2000 онд Жорж Мейсоны их сургууль төгссөн /бакалавр/
- 2004 онд Жорж Вашингтоны их сургууль төгссөн /магистр/
- Бизнесийн удирдлага, санхүүч мэргэжилтэй
- 2006-2007 онд Мянганы сорилын санд
- 2007-2009 онд “Си Си Пи” ХХК-д
- 2009 оноос одоо хүртэл “Си Би Эм” ХХК-д гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан
- 2014 оны 6-р сараас 2020 оны 10-р сар хүртэл “Шарын гол” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажилласан.



**Болдын Мэндсайхан**

- 1975 онд Улаанбаатар хотод төрсөн
- 1999 онд ХААИС-ийг эдийн засагч мэргэжлээр төгссөн
- 1999-2005 онд “Бэрх-Уул”ХК-д эдийн засагч
- 2005-2006 онд “Бэрх-Уул”ХК-д орлогч захирал
- 2006-2019 онд “Бэрх-Уул”ХК-д Гүйцэтгэх захирал
- 2022 оны 1-р сараас “Шарын гол” ХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



**Наранбадрахын Батнайрамдал**

- 1988 онд Өмнөговь аймагт төрсөн.
- 2010 онд ИЗИС-ийн “Чингэс-Соосэ” олон улсын харилцааны сургууль
- 2020 онд МУИС-ийн хууль зүйн сургууль
- Олон улсын эрх зүйч, хуульч мэргэжилтэй, хууль зүйн ухааны магистрын зэрэгтэй
- 2010-2012 онд Үнэмлэхүй эрх хуулийн фирмд хуульч
- 2013-2016 онд “Хэрлэн онон туул” ББСБ-д хуулийн зөвлөх
- 2016-2019 онд “Говь Караван” ХХК-д хуулийн зөвлөх
- 2020 оноос Өмгөөллийн “Би И Би партнерс” хуулийн фирмийн Гүйцэтгэх захирал, партнер

## Цэндсүрэнгийн Тэмүүлэн



- 1989 онд Улаанбаатар хотод төрсөн
- 2010 онд ШУТИС-ийг уул уурхайн менежмент мэргэжлээр төгссөн
- 2020 онд ШУТИС-д бизнесийн удирдлагын магистр
- 2010-2013 онд “Оюутбэл” ХХК-д төслийн эдийн засагч
- 2013-2015 онд “Оюутбэл” ХХК-д гүйцэтгэх захирал
- 2015-2017 онд Цөмийн энергийн комиссын ажлын албанд мэргэжилтэн
- 2017 оноос “Юнити Дата Техноложи” ГХОХХК-д бизнес хөгжил хариуцсан менежерээр ажиллаж байна.

## Баярсайханы Пүрэвбаатар



- 1986 онд төрсөн
- 2010 онд Санхүү эдийн засгийн дээд сургуулийг санхүүгийн менежмент мэргэжлээр төгссөн
- 2010-2011 онд “Фронтиер секюритиз” ХХК-д санхүүч
- 2011 онд АНУ-ын хөрөнгө оруулалтын санд ахлах шинжээч
- 2013 оноос Бэрх Уул, Багануур, Шивээ овоо, Нако түлш ХК-д ТУЗ-ийн гишүүн
- 2016 онд Хай Би Ойл ХК-д санхүү эрхэлсэн дэд захирал, 2020 оноос ТУЗ-ийн дарга
- 2016 оноос Хэрлэн он Туул ББСБ-д гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



## Тэрбишийн Говьдэлгэр

- 1984 онд Говь-Алтай аймагт төрсөн.
- 2001 онд Говь-Алтай аймгийн 10 жилийн сургууль
- 2001-2005 онд МУИС-ийн ГГФ-ийг геологич мэргэжлээр төгссөн.
- 2005-2007 онд “Адемас майнинг” ХХК-д геологич
- 2007-2011 онд “Вюмир майплесон” ХХК-д геологич
- 2011-2015 онд “Си Би Эм” ХХК-д геологич
- 2015-2017 онд “Говь караван” ХХК-д геологич
- 2017 оноос “Нагай” ХХК-д геологичоор ажиллаж байна.



**Хүрэлбаатарын Уянга**

- 1986 онд Улаанбаатар хотод төрсөн
- 2007 онд ШУТИС төгссөн
- 2008 онд Отгонтэнгэр Их сургууль төгссөн
- 2014 онд БНХАУ, Chongqing их сургууль төгссөн
- Бизнесийн удирдлага, уул уурхайн эдийн засагч, кадастр-газар зохион байгуулалтын инженер мэргэжилтэй
- 2007-2010 онд “Монголын Алт” ХХК-д ерөнхийлөгчийн туслах, цалингийн нярав, Зоос банканд зах зээлийн эдийн засагч, аудитор
- 2012-2013 онд “Монголын Алт” ХХК-д зах зээл судлаач, оффис менежер
- 2014-2020 онд “Шарын гол” ХК-д хөрөнгө оруулалт, эдийн засгийн мэргэжилтэн, төслийн менежер
- 2020 оны 10-р сараас 2022 оны 1-р сар хүртэл “Шарын гол” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажилласан.
- 2021 оноос Шарын гол ХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажилласан.

**Батбаярын Тулга**



- 1986 онд Дархан-Уул аймагт төрсөн
- 2008 онд Санхүү Эдийн засгийн сургууль
- Бизнесийн эдийн засагч мэргэжилтэй
- 2008-2009 онд Зоос банканд зах зээлийн эдийн засагч, аудитор
- 2009-2011 онд Төрийн банканд хянан шалгагч, зах зээл үйл ажиллагааны эрсдэл
- 2011-2012 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банканд эрсдэлийн эдийн засагч
- 2012-2013 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банканд зээлийн эдийн засагч
- 2013-2016 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байгууллагын санхүүжилтийн хэлтсийн дарга
- 2016-2017 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байгууллагын банкны газрын дарга
- 2017 оноос Үндэсний хөрөнгө оруулалтын банкны гүйцэтгэх захирлаар.

**Хараат бус гишүүнд нэр дэвшигчид**



**Жамаагийн Эрдэнэбат**

- 1960 онд Улаанбаатар хотод төрсөн
- 1984 онд ОХУ-ын Кривой Рог-ын УУДСургууль
- 2008 онд ШУТИС-д магистрын зэрэг хамгаалсан
- Уул уурхайн инженер, маркшейдер мэргэжилтэй
- Монгол Улсын зөвлөх инженер
- Монгол Улсын гавьяат уурхайчин
- 1984-2020 онд Шарын гол ХК-д хэсгийн болон ерөнхий маркшейдер, ерөнхий инженер удирдлагын магистр



**Гэрэлийн Хулан**

- 1985 онд Токио хотод төрсөн
- 2000 онд Японы "Шото" дунд сургууль
- 2004 онд Японы "Кокусан" ахлах сургууль
- 2008 онд Японы Азийн их сургууль тус тус төгссөн
- Гадаад харилцааны мэргэжилтэй
- 2011-2013 онд "Солонго Эко Кампинг" ХХК-ийн ерөнхий захирал
- 2014-2018 онд "Интернашионал Смарт Акуа Калча" /ИСАК/ ерөнхий менежер
- 2017-2018 онд "Данфийн ГХО" ХХК гүйцэтгэх захирлаар одоо хүртэл ажиллаж байна
- 2018 оноос "Шарын гол ХК-ийн" ТУЗ-ын дарга.

**Болдын Итгэл**



- 1986 онд Улаанбаатар хотод төрсөн
- 2005 онд АНУ-ын Иорктауны ахлах сургууль
- 2008 онд АНУ-ын Жорж Мейсоны их сургууль тус тус төгссөн
- Санхүүч мэргэжилтэй
- 2009-2010 онд Хаан банканд теллер, зээлийн эдийн засагч, харилцааны менежер
- 2010-2013 онд "Ньюком" ХХК-д шинжээч, хөрөнгө оруулалтын менежер
- 2013 оноос одоо хүртэл "Нова Терра" ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.
- 2018 оноос "Шарын гол" ХК-ийн ТУЗ-ийн гишүүн

**"ШАРЫН ГОЛ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН**
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

2023.04.21 дугаар 03 Улаанбаатар хот

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн
ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт, компанийн дүрмийн 8.3 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд
   -
   -
   -
   -
   -
   -
   Хараат бус гишүүнд
   -
   -
   - нарыг

2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрөөс 2025 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл 2 жилийн хугацаагаар сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ХУЛАН

**"ШАРЫН ГОЛ" ХУВЬЦААТ КОМПАНИЙН**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**
**ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 13 өдөр Дугаар 01 Улаанбаатар хот

Ногдол ашгийн тухай

"Шарын гол" ХК-ийн үйл ажиллагааг хэвийн явуулах, сайжруулахад нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа болон өр төлбөртэй байгаагаас шалтгаалан ногдол ашиг хуваарилах санхүүгийн нөхцөл бүрдээгүй тул Компанийн тухай хуулийн 46.1, компанийн дүрмийн 12 дугаар бүлгийн заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2022 оны жилийн ажлын үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.

2. Энэхүү тогтоол, түүнтэй холбогдсон шалтгаан, тооцоолол бүхий тайлбарыг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Мэндсайхан/-д даалгасугай.

ДАРГА Г.ХУЛАН

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны
..... дугаар тогтоолын хавсралт №1

*“Шарын гол” ХК -ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлаар хувьцаа эзэмшигчээс*

**_САНАЛ АВАХ ХУУДАС_**

*Хувьцаа эзэмшигчийн овог .................................. нэр ................................*
*Регистрийн дугаар ....................................*
*ХЭ-ийн бүртгэлийн дугаар ..........................*
*Эзэмшиж буй хувьцааны төрөл .................*
*Тоо ..................*

*Хурал 2023 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 15 цагаас Дархан-Уул аймаг, Шарын гол сум, 3-р баг, Санжинт хаягт байрлах “Шарын гол” ХК-ийн өөрийн байрны 2 давхарын хурлын танхимд болно.*

| ***д/д*** | ***Хэлэлцэх асуудлын нэр*** | | ***Хурлаас гарах шийдвэрийн төсөл*** | ***Зөвшөөрсөн*** | ***Татгалзсан*** | ***Түдгэлзсэн*** | ***Татгалзсан тохиолдолд таны өгөх санал*** |
|---|---|---|---|---|---|---|---|
| ***1*** | *Компанийн 2022 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт.* | | *Тогтоол<br><br>ТУЗ-ийн дүгнэлтийг батлах* | | | | |
| ***2*** | *Компанийн ТУЗ-ийн гишүүдийн 2023 оны цалин урамшуулал, зардлын төсвийг батлах* | | *Тогтоол<br><br>Зардлын төсвийг батлах* | | | | |
| ***3*** | *Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгох* | | | *Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо /кумулятив аргаар/* | | | |
| | *1* | Б.Батбаатар | | | | | |
| | *2* | Х.Уянга | | | | | |
| | *3* | Н.Батнайрамдал | | | | | |
| | *4* | Б.Пүрэвбаатар | | | | | |
| | *5* | Б.Мэндсайхан | | | | | |
| | *6* | Ц.Тэмүүлэн | | | | | |
| | *7* | Т.Говьдэлгэр | | | | | |
| | *8* | Б.Тулга | | | | | |

| | Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох | | Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо /кумулятив аргаар/ |
|---|---|---|---|
| | 1 | Б.Итгэл | |
| | 2 | Ж.Эрдэнэбат | |
| | 3 | Г.Хулан | |

***Саналын хуудас хүлээн авах эцсийн өдөр 4 дүгээр сарын 21 болно.***

*Санал өгсөн хувьцаа эзэмшигчийн гарын үсэг* ............................................................
*Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон*
*Тооллогын комиссын дарга* ........................
*гишүүд:* ........................................................
........................................................
*Хүчингүйд тооцсон бол шалтгаан*
..........................................................................................................................................
..........................................................................................................................................

***Санал авах хуудсын ашиглах санамж***

1. Санал өгөх тэмдэглэл √ тэмдэглэнэ.
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгоход санал хураах Кумулятив аргыг хэрэглэнэ. Кумулятив аргаар санал өгөх тоо _____________
3. Тайлбар: саналын эрх бүхий энгийн хувьцааны тоог 9-өөр үржүүлж нийт саналын эрхийн тоог гаргана. Саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.

   **Хувилбар А:** Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.

   **Хувилбар Б:** Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.
4. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч брокерийн пүүс болон “Шарын гол” ХК-ийн УБ дахь Төлөөлөгчийн газар дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгч болно.
5. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг 88026677, 99155399  утсаар лавлаж болно.